

**“БОГД БАНК ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС
ГИШҮҮН ЖАМБАЛСҮРЭН ОВОГТОЙ НАРАНТУЯАГИЙН 2022 ОНЫ
2-Р ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН”**

Миний бие Богд Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр 2014 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөс томилогдон ажилласнаас хойш өдгөө 9 дахь жилдээ хараат бус гишүүний чиг үүргээ биелүүлэн ажиллаж байна. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга, Хүний нөөцийн хорооны даргаар томилогдон ажиллаж байгаад ТУЗ-ийн 2022.09.29-ний өдрийн 22/88 тоот тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх, Нэр дэвшүүлэх, үнэлгээ урамшууллын хороо, Хүний нөөцийн хорооны гишүүнээр томилогдсон.

Тайлант хугацаанд Аудитын хорооны даргын чиг үүргийг гүйцэтгэж байх хугацаандаа доорх чиглэлийн дагуу 3 удаа хуралдуулж Дотоод аудитын газраас бэлтгэсэн аудитын тайлан, дүгнэлттэй тухай бүр танилцаж, чиглэл өгч ажилласан. Богд банкны залилангийн эсрэг баримтлах бодлогод санал өгч ажилласан

1. 2022.08.01 -Богд банкны залилангийн эсрэг баримтлах бодлого
2. 2022.09.08 -Худалдан авалтын үйл ажиллагааны аудитын тайлангийн эргэн хяналт, Зарим салбарын зээлийн үйл ажиллагааны аудит
3. 2022.09.13 – Хөндлөгийн аудитын байгууллага сонгох тухай.

2022.09.29-ний өдрийн ТУЗ тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх, Нэр дэвшүүлэх, үнэлгээ урамшууллын хороо, Хүний нөөцийн хорооны гишүүнээр томилогдож дараах чиг үүргийн хүрээнд ажиллаж байна.

- Банкны хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг хангахтай холбоотой журам дүрэмтэй танилцаж, хянан хэлэлцэж, баримтуудыг хянаж, тогтмол сайжруулах,
- Компанийн удирдах ажилтны цалин, урамшууллын бодлогыг тодорхойлон, хэрэгжилтийг хянах
- Компанийн хэмжээнд баримтлах цалин, урамшууллын бодлого, хөтөлбөрүүдтэй танилцаж, дүгнэлт гаргах
- Хороо нь ТУЗ-ийн гишүүнийг нэр дэвшүүлэх, үнэлэх үйл ажиллагааг хангах чиглэлийг баримтлан ажиллах

Тайлант хугацаанд ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх, үнэлгээ, урамшууллын хорооны ажиллах журмын боловсруулалт санал, зөвлөмжийг өгч хороо болон гишүүд, даргын ажлыг үнэлэх үнэлгээний хуудсыг боловсруулж ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж баталсан. Мөн хүний нөөцийн хорооны 11 дүгээр сарын 22 - ны хуралд цахимаар оролцож өөрийн саналын өгч ажилласан байна.

2022 оны 2 дугаар хагас жилд ТУЗ-ийн нийт 38 удаагийн хуралд оролцсон ба Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журмын 5.2.3 дах заалтын дагуу Их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчилтэй дараах 8 тогтоолд санал өгсөн.



**“БОГД БАНК ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС
 ГИШҮҮН ЖАМБАЛСҮРЭН ОВОГТОЙ НАРАНТУЯАГИЙН 2022 ОНЫ
 2-Р ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН”**

ТУЗ-ийн тогтоол /утга/		Дугаар	Огноо
Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай	Зээлийн шугамын хэмжээг нэмэгдүүлэх тухай	22/96	2022.10.07
	Зээлийн шугамын хэмжээг нэмэгдүүлэх тухай	22/106	2022.11.03
	Зээл олгох тухай	22/123	2022.12.13
	Кредит карт олгох тухай	22/130	2022.12.23
	Кредит карт олгох тухай	22/131	2022.12.23
	Кредит карт олгох тухай	22/132	2022.12.23
	Кредит картын хугацаа сунгах тухай	22/133	2022.12.26
	Кредит картын хугацаа сунгах тухай	22/134	2022.12.26

Хорооны хурлуудад зарчмын зөрүүтэй санал гараагүй бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлөөгүй, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцэж ажилласан.

2022 оны 2 дугаар хагас жилд ТУЗ-өөс зарлагдсан бүх хуралд зайнаас оролцон саналаа өгч ТУЗ-ийн хараат бус гишүүний үүргээ 100% биелүүлж идэвхтэй ажилласан болно.

БОГД Банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн
2023.01.10

Ж.Нарантуяа